

Орчуулсан: Г.Лодой, доктор (Ph.D)

ШУА-ийн Философийн хүрээлэн

О.Болор-Эрдэнэ, магистр

ШУА-ийн Философийн хүрээлэн

ЭДМУНД ГУССЕРЛЬ. ФЕНОМЕНОЛОГИ

(“Britannica”-д хэвлэгдсэн тойм)

Удиртгал

“Феноменологи” бол философийн шинэ дескриптив арга юм. Уг аргад үндэслэн өнгөрсөн зууны эцэст:

- 1) Чанд үндэслэгээтэй эмпирик сэтгэл судлалын цорын ганц баттай суурь болж чадах априор сэтгэл судлалын ухаан;
- 2) Бүх шинжлэх ухааныг эрэмбэ дараалалтай хянан үзэх чухал зэмсгийг бидэнд олгох универсаль философи бий болжээ.

I ХЭСЭГ. ФЕНОМЕНОЛОГИЙН СЭТГЭЛ СУДЛАЛ

{Цэвэр сэтгэл судлалын гүйцэтгэх үүрэг, түүний туршлага хийгээд арга}

§ 1. Байгалийн болон сэтгэлийн судлагдахуун. Интенциональ туршлага

Цэвэр байгаль шинжлэл ба цэвэр сэтгэл судлал

Орчин үеийн сэтгэл судлал нь орон-цагт орших бодит юмсын холбоос дунд сэтгэцийг судалдаг, өөрөөр хэлбэл ертөнцөд EGO хэлбэрээр байгаа сэтгэлийн зүйлийг (ямар нэгэн сэтгэл хөдлөл хийгээд дадал чадвартай зүйлийг) хэрэглэгдэхүүнээ болгодог. Чухамдаа сэтгэцийн зүйл хүн хийгээд адгуус оршихуйн тодорхой үе

давхарга болж өгөгдсөн байхын хирээр сэтгэл судлалыг хүн судлал юм уу амьтан судлалын нэг салбар гэж үзэж болно. Гэтэл амьтны ертөнц бол биетийн хэсэг бөгөөд түүний бодит байдал нь [цэвэр] байгаль шинжлэлийн сэдэв мөн. Тэгвэл [цэвэр] байгаль шинжлэлийн зэрэгцээ цэвэр сэтгэл судлалыг бүтээ гэвэл биет зүйл, сэтгэлийн зүйл хоёрыг нарийн ялгах бололцоотой юу?

[мэдээж, зарим талаар цэвэр сэтгэлийн судалгаа гэж байх ёстой. Бидний мэдэх сэтгэцийн тухай ойлголтууд түүнээс улбаатай], гэвч цөөнгүй нь психофизик ойлголт болчихсон байдаг.

Сэтгэлийн тусгал, өөрийн туршлага ба хамтын туршлага

Цэвэр сэтгэл судлалын хөгжлийн асуудлыг шийдвэрлэх гэж оролдохоос өмнө, чухамдаа түүний туршлага хийгээд баримт сэлтийн өвөрмөц шинж чанарын талаар бид мэдэж авах ёстой. Ихэвчлэн хүмүүс өөрсдийн туршлагыг таньж дадсан байдаг боловч тухайн удирдамжийг өөрчлөлгүйгээр, өөрөөр хэлбэл туршлагад “тунгаах эргэцүүлэг” хийхгүйгээр сэтгэлийн зүйлийг илрүүлэх боломжгүй. Бид ямар нэгэн юм, санаа, эрхэмлэлийг анхааралдаа авдаг ч тэдгээрийг тусгаж танин мэдэх үйлийг мартдаг бололтой. Тусган авах энэхүү үйлийг тунгаах эргэцүүлэг хийж мэднэ. Ямар нэгэн юм, эрхэмлэл, зорилт хийгээд хэрэглэгдэхүүнийг орхиж, тэдгээрийн “мэдэгдэх” субъектив туршлагыг авч үзэх хэрэгтэй. Тэдгээрийн “мэдэгдэхүүн” бол феномен мөн. Түүний оногдохуун нь бодит юм байх эсэхээс үл хамааран, оногдохууны “тухай ухамсар” байх ёстой. Ухамсарт харьцангуй энэ шинж чанар эх хэлнээ:

“(нэг) юм бодож байлаа”, “(нэг) юмнаас айлаа” гэх мэт хэллэгт тусгалаа олжээ; феноменоос сэтгэцтэй холбогдох талын нь шинжлэхийн учир феноменологийн сэтгэл судлал хэмээх нэршил бий болсон. Харин схоластикуудын “интенциональ” хэмээх үгээр феномены “оногдохуун орон”-ыг тэмдэглэмүй. Аливаа ухамсар “интенциональ” амой.

Эхлээд тунгаасан эргэцүүлэггүй ухамсар оногдохуун руу “зүглэж” түүнийг “интенцижүүлнэ”. Энэ нь бид сэтгэлдээ тусган авсан маш олон зүйлд нийтлэг имманент үйл явц болохыг тунгаах эргэцүүлэгээр мэдэж болно. Ямар нэг юмыг ухамсарлах нь түүнийг ухамсарт дэмий эзэмшиж байхын нэр биш. Бүх феномен интенциональ бүтэцтэй агаад үзвэл тус бүр интенциональ төдийгүй хоорондоо интенциональ холбогдсон хэсгүүдийн өргөжсөөр буй тогтолцоо ажиглагдана. Жишээлбэл, кубыг хүртэх явцад ярвигтай эвцэлдсэн интенци илэрнэ. Үүнд: “алслал”-ын зохих ялгаа, наадах ба цаадах талын харагдах харагдахгүйн ялгаа бий болдог. Цаадах тал тухайн агшинд харагдахгүй ч оршихуйгаас хасагдахгүй нь ойлгомжтой. Эдгээр нь харах өнцгийн олон хувилбарт “мэдэгдэхүүн” юм. Энэ олон талт мэдэгдэхүүний “урсгал” хийгээд тэдгээрийн эвцэлдэх аргыг ажиглавал үе мөчлөг тус бүр нь аль хэдийн нэг юмны “тухай ухамсар” болох нь илэрхий. Шинэ тутам гарч ирэх үеүд нь бүхэллэг ухамсрынхаа синтетик нэгдлийн нэг агшныг ч алдагдуулахгүйгээр үл барам, бүгд нэг л объектын тухай ухамсар болж магадтайяа үлдэж байна. Хүртэхүй дамжин өнгөрөх интенциональ бүтэц [ярвигтай боловч хэрэгжих ёстой] тогтсон мөн чанарт хэв шинжтэй. Энэ нь бодит юмсыг хүртэхэд ч нэгэн адил үйлчилнэ! Хэрвээ объектын модус солигдвол, өөрөөр хэлбэл тэр нь төсөөлөл, дурдтагал, дуурайлтаар өгөгдвөл интенциональ хэлбэрүүд нь давтагдах ч шинж чанар нь хүртэхүйгээс шинэ модуст тохирохуйц байдлаар өөрчлөгдөнө. Ямар ч зүйл сэтгэлийн тусгал ийм байна. Дүгнэлт,

үнэлэлт, эрмэлзэл тус бүр өөрийн бодомж, үнэт зүйл, зорилго хийгээд хэрэгслийг ухамсарт дэмий эзэмшиж байгаа хэрэг биш, харин тус бүр зохих ёсны интенциональ урсгалтай, тогтсон мөн чанарт хэв шинжтэй сэтгэлийн тусгал болж.

Феноменологийн сэтгэл судлалын эцсийн зорилго нь интенциональ тусгалын хэлбэр ба хэв шинжийг цэгцлэх, тэдгээрийг бүтцийг анхдагч интенцэд шилжүүлэх замаар сэтгэцийн зүйлийн уг чанарт нэвтрэх хийгээд сэтгэл санааны амьдралыг танин мэдэхэд оршино.

Ийм судалгааны учир холбогдол сэтгэл судлаач гагцхүү өөрийн сэтгэл санааны төлөвийг танин мэдэхээр хязгаарлагдахгүй. Учир нь сэтгэл санааны амьдрал аваас бидний өөрийн-ухамсраас төдийгүй бидний бусад “би”-тэй сүлэлдсэн ухамсраас эхэлнэ. Дурдан буй удаах эх сурвалж дотор, бид өөрсдийн өөрийн-ухамсраас олж хардаг зүйлсийг давтан өгүүлэх төдийгөөс илүү зүйл хадгалагдаж байдгийн учир нь “өөрийн” ба “бусдын” ялгалын үндэс болдог. Үүнээс бидний мэдэх “нийгэмлэгийн амьдрал” эхэлдэг. Иймд, феноменологийн сэтгэл судлалын цаашдын зорилго бол хамтын амьдралыг бүтээдэг интенцүүдийг нээх явдал юм.

§ 2. Феноменологи редукцын явцад түгжигдсэн талбар.

Сэтгэл судлалын редукц ба дотоод туршлага

Тэгэхлээр феноменологийн сэтгэл судлал нь өөрийн “Би”-гийн туршлага, түүнээс бусад “Би”-гийн туршлага, цаашлаад хамтын туршлагыг шинжлэх болж байна. Тийм боловч психо-физикийн буюу биетийн эрхшээсэн сэтгэцийн зүйлээс эрхбиш ангид эсэх нь тодорхойгүй үлдэж байна. Дор хаяж, өөрийн “Би”-гийн цэвэр туршлага, цэвэр сэтгэлийн өгөгдөхүүнд хүрэх боломжтой билүү? Тэр бүү хэл, энэ бэрхшээл нь, интенциональ

төлөв нь сэтгэлийн зүйлийн гол шинж болохыг Брентано нээсний дараа ч, сэтгэл судлаачдыг феноменологийн сэтгэлзүй байж болох талаар ухааралд хүргээгүй билээ. Сэтгэл судлаач нэгэн өөрийнхөө туршлагыг ямагт “гадаад” туршлагатай, сэтгэцийн гаднах юмстай холбогдолтойг олж хардаг. Хэдийгээр энд гаднах юмсыг сэтгэцэд туршсан мэт байдаг боловч гаднаас туршлагад өгөгдсөн зүйл интенциональ “дотоод амьдрал”-д хамаардаггүй. Гагцхүү феноменыг олж тогтоох, гагцхүү өөрийн “амьдралын үйл”-ийг танин мэдэх хүсэлтэй феноменологич нэгэн *ἐποχή* (*эпохе*)-г баримталбал зохино. Ер дурын “байр суурь”-ийг хориглож, объектив ертөнцийг хөндсөн ямар ч дүгнэлтээс татгалзах учиртай. Туршлагыг яг байснаар нь: энэ гэрийн, энэ биеийн, энэ ертөнцийн туршлага буй төрхөөр нь үлдэнэ. Учир гэвэл, танин мэдэхүйн объект болж сэтгэлд юу тусаж байгааг, - тэр нь бүр “эндүүрч харсан зүйл”, зөрчилтэй бодомж ч байсан хамаагүй, яг тоочилгүйгээр ямар ч интенциональ тусгалыг хэлэх боломжгүй.

Бидний ярилцдагаар, манай универсаль *ἐποχή* ертөнцийг “хашиж”, түүнийг (энд ердөө байж байгаа ертөнцийг!) субъектийн талбараас огцруулна, оронд нь тэгж тэгж туршигдаж: нэг үгээр бол хүртэгдэж, дурдагдаж, үнэлэгдэж, дүгнэгдэж байгаа “хашилттай” ертөнцийг үлдэнэ. Ингэснээр ертөнц юм уу түүний нэг хэсэг биш, ертөнцийн “утга учир” мэдэгдэж ирнэ. Феноменологи туршлагын талбарт нэвтрэхийн тулд бид жам ёсны удирдамж доторх объектоос тэдгээрийн олон янзын модуст мэдэгдэх байдал руу, “хашилттай” объектод буцаж очих ёстой.

Цэвэр сэтгэлийн зүйл, феноменд хүрэхийн гэвэл хоёр түвшинд феноменологи редукцийг дамжин өнгөрөх болдог: *нэгдүгээрт*, сэтгэлийн тусгалыг объективчлохоос ерөөсөө зайлсхийх, нэгж феномен төдийгүй сэтгэлийн амьдралын

бүхэл бүтцийг авч үзэхдээ ч *ἐποχή*-г чанд баримтлах; *хоёрдугаарт*, нэгэнт “объект” биш, харин “утгын нэгж” болчихсон олон “мэдэгдэхүүн”-ийг аль чадах хирээр олж, таниж, тоочих хэрэгтэй. Ийнхүү хоёр чиглэлд феноменологи тоочилтыг хийж болно. Ноэтик (*νόεω*) ба ноэматик зүйлийн (*νόημα*) тоочилт, өөрөөр хэлбэл сэтгэлд тусгах үйлийн тоочилт ба сэтгэл туссан юмсын тоочилт орно. Үгийн бүрэн утгаар “дотоод” гэж нэрлэж болохоор цорын ганц туршлага бол феноменологи туршлага юм; түүнийг хэрэгжүүлэхүйд хязгаар үгүй билээ. Тэгж объектив зүйлийг “хашилтад” хийсний дараах “мэдэгдэхүүн”-ийг (ноэзис дэх ноэмаг) тоочихуйг бусад “Би”-гийн амьдрал дээр мөн адил үйлдэж, “репродуктив” аргаар өөрийн туршлагаас бусад “Би”-гийн туршлагын талбар руу дэлгэрүүлэн хэрэглэж болно. Цаашилбал, хамтын ухамсраас бидний туршлагад үүсэх нийтлэгийг хувийн ухамсрын талбарт шилжүүлэн редукцлэх, нөгөөтэйгүүр интерсубъектив редукцээр хамтын амьдралын феноменологи нэгдэлд хүрэх боломжтой. Сэтгэл судлалын дотоод туршлагын тухай ойлголт өргөжсөөр ийнхүү гүйцнэ.

Тийм боловч сэтгэл нь “утгын нэгжүүд”-ийн барилдлагаас бүтсэн “интенциональ амьдрал”-ын олон талын нэгдлээс ямагт илүү байдаг. Учир гэвэл тусгаар интенцүүд хийгээд түүнд дулдуйдах “төлөвшлүүд”-ийн төв тэнхлэг болсон “адилсах эго” гэж бий, тийм “эго-субъект” нь интенциональ амьдралтай салшгүй холбоотой. Феноменологи редукцийг дамжин өнгөрч баттай таньсан интерсубъектив төлөв бол ухамсартай амьдралд интерсубъектив хэлбэрээр оролцож буй “хүмүүсийн хамтлаг” мөн.

Феноменологийн сэтгэл судлал ба эйдетик ухаан, эйдетик редукц

Феноменологийн сэтгэл судлалаас эмпирик, психофизик элементүүдийг суутгасан нөхцөлд “бодит үйл явц”

(“*matters of fact*”) руу нэвтрэх аргагүйд хүрнэ. Нэгэнт түгжигдсэн талбар бүрээс тэдгээрийн “мөн чанар”, “*εἶδος*”-ыг авч үзэхдээ, бид феномены бодит өрнөлийн талыг хэрэгсэхгүй, хэрэг гарвал зөвхөн “жишээ” болгон ашиглаж болно. Хувийн болон хамтын сэтгэл санааны амьдралын “боломжит” хэлбэрүүд агаад а-приори-ийг шинжлэхийн тулд тэдгээрийг буй төрхөөр нь орхино. Хувь хувилбаруудаас инвариант зүйлийг олж тогтоож, а-приори хэв шинжийн талбарыг нээнэ. Сэтгэцийн аливаа баримт сэлтийн хэв шинжийн онцлогийг илрүүлнэ. Манай удирдамж “онолын шинжтэй” болж байгаа юм. Сэтгэл судлалын феноменологи нь эйдетик феноменологи дээр суурилах ёстой.

Жишээлэн үзүүлбэл, биетийг хүртэхүйн феноменологи гэдэг нь хүртэхүйд бодитой болж байгаа эсвэл удалгүй болох үйл явцыг тайлбарлахгүй, харин биетийн хэсгүүдийг ч тэдгээрийн шүтэлцээ үргэлжлэлийг ч хүртэхэд зайлшгүй шаардлагатай инвариант “бүтцүүд”-ийг гаргахтай холбогдоно. Сэтгэл судлалын редукц нь үнэнхүү дотоод туршлагын феноменыг нээнэ; эйдетик редукц нь сэтгэцийн ахуйгаас тогтсон мөн чанарт хэлбэрүүдийг нээнэ.

Феноменологийн цэвэр сэтгэл судлал нь оновчтой эмпирик сэтгэл судлалын үндэс болдог

Орчин үед философиос байгаль шинжлэлийн оновчтой байдлыг шаардах болжээ. Эмпирик индуктив байгаль шинжлэл нь нэгэн үе төлөвшин тогтож амжаагүй байсан ба орчин үеийн дүр төрхөө онолын геометр зэрэг салбарт хөгжсөн Хөдөлгөөний хууль, Цаг хугацаа гэх мэт ерөөс байгалийг таних хэлбэрүүдийн а-приор тогтолцооны ачаар олсон. Байгаль шинжлэл, сэтгэл судлал хоёрын арга ялгаатай ч сэтгэл судлал нь байгаль шинжлэлийн адил “мөн чанарын зүйл”-ийг рационалжуулах замаар оновчтой болдог.

“Мэдээж, психофизик зүйл өөрийн а-приоритой учир сэтгэл судлалын а-приор нь феноменологийн а-приоритой бүрэн дүйцэхгүй. Гэвч сэтгэл судлал нь цэвэр феноменологи а-приори, бас физик (ялангуяа, органик) а-приори байхыг шаардана”

II ХЭСЭГ. ТРАНСЦЕНДЕНТАЛЬ ФЕНОМЕНОЛОГИ

{Феноменологийн сэтгэл судлал ба трансценденталь феноменологи}

§ 3. Локк, Декарт нараас эхлэлтэй трансценденталь философийн асуудал

Декартын трансценденталь эргэлт ба Локкын психологизм

Декартаас трансценденталь феноменологи, Локк, Беркли, Юм нараас феноменологийн сэтгэл судлал эхлэлтэй. Ямар ч атугай феноменологийн сэтгэл судлал гагцхүү сэтгэл судлалд үйлчлэх зорилготой салбар юм уу арга байсангүй, харин Декартын томьёолсон трансценденталь асуудалын шийдийг олох оролдлого маягаар гарч ирсэн билээ. Энэ асуудалд холбогдолтой философид “Эргэцүүлүүд” зохиолд хөндсөн сэдвүүд чухал байр эзэлдэг. Энэ философийн үзэл ёсоор, бидний хүртэж танил болсон ертөнц, ер аливаа бодит байдал гэгч нь зөвхөн бидний бодол санааны тусгалууд болж оршдог, нэг үгээр хэлбэл бидний бодол дүгнэлтээс урган гарсан, шалгагдаж тогтоогдсон юмс байдаг. Трансценденталь асуудлын тухай санаа зөв буруу олон хувилбар дайралдаж байдгийг бид бүхэн мэднэ.

Декартын эргэлзэх арга нь чухамдаа “трансценденталь субъектив төлөв”-ийг нээсэн бөгөөд EGO COGITO баримтлалыг боловсруулсан буй. Хожим нь Картезийн трансценденталь “MENS” нь Локкын

судлах гэж оролдсон “Хүний оюун ухаан” болж, мөн Локкын судалгаа нь дотоод туршлагын сэтгэл судлал болж таарав. Энэ нь трансценденталь асуудлыг сэтгэл судлалын хүрээнд авч үзээд шийдвэрлэх гэж оролдсонтой холбоотой. Тэрээр амь гол бөхтэй сэтгэл судлалын хуурамч философийн үндэслэгч болж орхисны учир эдүгээ хүртэл “субъектив зүйл” тухай ойлголтын давхар утга санааг хэн ч нягталж байгаагүйд оршино. Хэрвээ трансценденталь асуудалд зохих ёсоор нь хандвал, “субъектив зүйл”-ийн давхардсан утга санааг таньж болохоор барахгүй түүний утга холбогдлын нэг тохиолдлыг феноменологийн сэтгэл судлал, нөгөө тохиолдлыг трансценденталь философи шинжилдгийг тогтоож болно.

Трансценденталь эргэлтээр психологизмыг даван туулах нь

Феноменологийн сэтгэл судлал нь зарим талаар философид хөл тавих тохиромжтой шат болдог, зарим талаар трансценденталь философиос илүүтэй ердийн удирдамжид ойрхон учраас энэ тойм өгүүлэлд гол төлөв түүнийг өгүүллээ. Сэтгэл судлал нь, сэдвээ утган авдаг ертөнц хийгээд “жам ёсны удирдамж”-ийн хамт, эйдетик болон эмпирик аль ч дэг салбарынхаа хүрээнд “позитив шинжлэх ухаан” мөн. Тийм аваас трансценденталь туршлагын дэгийг хэрэгжүүлж дийлэхгүй. Трансценденталь туршлага бол “ертөнцөөс хэтийдсэн” “эцсийн” туршлага юм. Феноменологийн сэтгэл судлал нь оргүй байсан зүйл биш боловч түүнд интенциональ шинжилгээ бий болсноор шинэ салбарт тооцогдох болсон. Тэр нь ямар ч позитив шинжлэх ухаанд нээлттэй. Түүнд суралцагчаас аргын хувьд аль чадах хирээр редукцын механизмийг чанд сахих, трансценденталь феноменыг илрүүлэх шинжилгээг шаардана.

Нэгэн зүйлийг тэмдэглэхэд, аль ч сэтгэл судлалаас хамаарахгүйгээр трансценденталь феноменологийг

хөгжүүлэх боломжтойд эргэлзэх учиргүй.

Трансценденталь асуудал

Ухамсрын давхардсан чигийг нээсэн нь хоёр зүйл редукцыг хэрэгжүүлж болохыг илтгэнэ. Сэтгэл судлал нь бодит юм оршихуйтай харьцдаг учир сэтгэл судлалын редукц нь адгуусны ертөнцийн бодит байдлын нэгэн түвшин болсон сэтгэлийн зүйлээр хязгаарлагддаг, тэр битгий хэл түүний эйдетик дэг ч бодит ертөнцийн боломжоос хэтрэхгүй. Гэтэл трансценденталь асуудал “бүхлийг эргэлзээнд оруулах” тул бүх шинжлэх ухааны судлагдахуун болсон ертөнц бүгдийг багтаана. Декарт учирласнаар, ертөнц нь бидний дотор “бүрэлддэг” бөгөөд ерөөс ертөнц хийгээд түүний аль нэг хэсгийн утга учрыг дотроос оноодог. Тэр нь хүртэх, төсөөлөх, бодох, амьдралыг үнэлэх явцад ухааран ухамсарлаж байгаа зүйл, нэг ёсондоо аль нэг субъектив генезис дотор “зохиомжилсон” ямар нэг юм мөн.

Хэн нэгэн ухаарч мэдсэн эсэхээс үл шалтгаалан, ертөнц хийгээд түүний шинж чанар нь “өөрийнхөөр буй ба өөрийнхөө тулд орших” нь гарцаагүй. Чингээд ертөнц нь “энэ” ухамсарт хүн хэмээгчид “мэдэгдэж” ирээд субъектив төлөвт холбогдолтой болохын цагт бүрэн ойлгомжтой эсвэл “асуудалтай” болж оршин ахуйн шинэ хэмжүүрт орно. Эндээс л трансценденталь асуудал үүсдэг. Учир холбогдол нь гагцхүү “субъектив байдалтай” энэ “мэдэгдэхүүн”, энэ “ертөнц-бидний-тулд-ахуй” гэгч чухамдаа юу сан билээ? Юутай ч ухамсарт холбогдолтой тул “дотоод” ертөнц гэж болох юм. Тэгвэл ухамсарт “оршдог” нэн бүрхэг “имманент ахуй” бүхий энэ “бүх” ертөнц нь бие тусгаар оршин буй мэт сэтгэлд тусдаг тэдгээр олон янз талуудын хамт, бидний өмнө, яаж тэгж эвийг олж гарч ирээд байна вэ? Энэ асуудлыг “идеаль” ертөнц, цэвэр тоо, тухайлбал “өөртөө буй үнэн”-д ч холбогдуулан үзэж болно. Хэрэг

дээрээ бид өөрсдөөсөө өөр ямар ч оршихуй ба оршихуйн аргыг бүрэн танин мэдэх аргагүй байдаг. Бид бүхэн, өөрөө өөртөө ба хамтдаа, ертөнцийг бодит байдалтай болгодог ухамсарт хүмүүн, өөрсдөө ч ертөнцөд хамаарах нь дамжиггүй.

Трансценденталь редуц ба зэргэлдээ субъектив төлөв

Тэгвэл бид нэг талаас сэтгэл судлалын тухайлдаг сэтгэлийн амьдралын субъект атал, нөгөөтээгүүр өөрөөс болон ертөнцөөс ангид байж ертөнцийг трансценденталь зохиомжлон буй амьдралын субъект болох уу? Өдөр тутам бидний танил болсон “Би” ба “Бид” гэх мэт сэтгэлийн субъектив төлөв нь сэтгэл судлалын редуц, эйдетик редуцгийн явцад феноменологийн сэтгэл судлалын үндэс болох боломжтой. Харин хэл мөхөстснөөс “би өөрөө”, “бид өөрсдөө” гэж ахин дахин хэлэхээс эс хэтрэх трансценденталь субъектив төлөвийг сэтгэл судлал юм уу байгаль шинжлэлийн аргаар олж илрүүлэх боломжгүй. Трансценденталь субъектив төлөв бол объектив ертөнцийн хэсэг огт биш, ертөнц агаад түүний агуулга бүхэн “миний тулд”, “бидний тулд” бүтээгдэж байгаа ухамсарт субъектив амьдралд хамаатай.

Бие хийгээд сэтгэлээр ертөнцөд оршин буй хүмүүн, бид өөрөө өөртөө “мэдэгдэхүүн”, “бид” зохиомжилсон зүйлийн нэг хэсэг, “биднээр” зохиогдсон утгын нэгжүүд болой. Мэдэгдэж байгаа “Би” ба “Бид” хэмээгчийн цаана далд “Би ба Бид” тэргүүтэн буй. Тэдгээртэй харьцуулахад эхнийх нь “бэлэн зэлэн” байна.

Ийм трансценденталь субъектив төлөв руу трансценденталь туршлагаар дамжин нэвтэрнэ. Цэвэр трансценденталь туршлагад хүрэхийн тулд сэтгэл судлалын туршлагын тохиолдолтой ижилхэн редуц шаардлагатай. Трансценденталь редуццын сэтгэл судлалын туршлага дээр хийсэн

редуццын үргэлжлэл гэж үзэж болно. Өдгөө универсаль эпохе дараах шатанд шилжинэ. Үүнд “хашилтад” хийх ажиллагааг ертөнцөөс цааш улируулж “сэтгэлийн зүйл” дээр хэрэглэнэ. Сэтгэл судлаач нь танил дасал болсон ертөнцийг түүний нэг хэсэг болсон “сэтгэл” хэмээгчдийн субъектив төлөвт редуцлэнэ [герман хувилбарт нь “сэтгэл судлаачийн өөрт нь танил дасал болсон ертөнц-дотор-тохиолдох-зүйлийн субъектив төлөвийг цэвэр сэтгэлийн субъектив төлөвт редуцлэнэ” гэж байдаг ажээ]. Трансценденталь феноменологич нь сэтгэл судлалын талаас ангижирсан субъектив төлөвийг трансценденталь субъектив төлөвт редуцлэнэ. Нэг үгээр хэлбэл, ертөнц ба түүний “сэтгэл” -ийн давхаргыг зохиомжилж буй универсаль субъектив төлөв редуцлэнэ.

Миний сэтгэцийн туршлага болсон зовнил, төсөөлөл зэрэг сэтгэл судлалын өгөгдөхүүнүүд анхааралд өртөхөөргүй болсноор трансценденталь туршлагыг шинжлэх ажил эхэлнэ. Миний бодит оршихуй сонирхлын талбараас гарна. Сэтгэцийн бодит туршлагыг өөртөө багтаасан цэвэр интенциональ амьдралд сонирхол төвлөрнө. Энэ алхам трансценденталь асуудлын (ухамсарт холбогдолтой трансценденталь ахуйн) утга учрыг бодитой болгоно. Зөвхөн бодит ертөнц ухамсарт холбогдолтой байдаггүй, эйдетик шаардлагад үндэслэвэл танин мэдэхүйн аливаа ертөнц ухамсарт холбогдолтойг зөвшөөрөх нь зүйтэй. Бид бодит ертөнцийн хэчнээн ч хувилбарыг фантазиар үүсгэж болно. Бид төсөөлж чадахаар ямар ч ертөнцийг бүтээсэн тэр бүхэнд зохицон өөрсдийгөө бас хувиргах хэрэгтэй болдог. Гэтэл бид өөрсдийгөө өөрчилсөн ч бидэнд заяасан субъектив төлөвийн хязгаараас эс хэтэрнэ. Бидний фантазид бүтсэн ертөнц бүхэн бидний туршлагад гарцаагүй өртсөн, өөрөөр хэлбэл бидний аж төрөх онол номлолын илт чанараар нотлогдсон ертөнц байх болно. Трансценденталь асуудал нь эйдетик асуудал бөлгөө. Миний хүртэхүй, төсөөлөл

зэрэг сэтгэл судлалын туршлагын агуулга ба хэлбэр өөрчлөгдөхгүй хэвэндээ үлдэх ч эдүгээ тэдгээрийг “бүтэц”-ийн хувьд авч үзэж байгаа нь ухамсрын эцсийн бүтцүүдтэй тулгарч байгаагаар холбоотой.

Утга учир бүхий аливаа асуудал эргэлзэхийн аргагүй үндэстэй, түүнд шийдвэрлэх арга хэрэгслүүд нь агуулагдсан байдгийн адил трансценденталь асуудалд ч тийм үндэс бий. Тэр нь боломжит ертөнцийг бодитоор зохиомжилж буй ухамсрын амьдралын субъектив төлөвөөс өөр юм биш. Нөгөөтээгүүр, рациональ аргын үндэс болгох учиртай аяндаа илэрхий зарчим гэвэл, нэгэнт гарцаагүй оршин буй энэ үндсийг трансценденталь асуудлын универсаль шинж чанарт хамаарах юмстай хольж хутгахгүй байхад оршино. Трансценденталь асуудалд хамаарах юмсын хүрээ нь трансценденталь хайхрамжгүй байдлын талбар юм. Тиймээс энд жам ёсны удирдамжийн аливаа боломжит ертөнц хамаарна. Тэгэхлээр бүх позитив шинжлэх ухаан нь судлагдахууны хамт, ялангуяа сэтгэл судлал нь сэтгэл гэж үздэг зүйлийнхээ хамт трансценденталь эпохег дамжин гарах ёстой. Эмпирик эсвэл эйдетик-феноменологийн сэтгэл судлалын аль нь ч ялгаагүй, хэрэв бид сэтгэл судлалаас трансценденталь асуудлын тайлалыг эрвэл трансценденталь тойрогт орооцолдох нь тодорхой. Ухамсар, субъектив төлөв хоёрт бид давхар төлөвийн парадокстой тулгарна (трансценденталь асуудал биднийг үүнд хөтлөнө). Энд сэтгэл судлалын судлагдахуун болсон ухамсар, субъектив төлөв нь нэг өөр байна. Сэтгэл судлалын редукц нь трансценденталь редукцээр солигдох учиртай. Баттай таньсан трансценденталь “Би ба “Би”-ийн нийгэмлэг нь сэтгэл ба сэтгэлийн амьдралын нийгэмлэг гэж ахин нэг баттай таньсан сэтгэл судлалын ердийн утга бүхий “Би” ба “Бид” тэргүүтэнтэй зэргэлдээ оршдог. Мэдээж, миний трансценденталь “Би” жам ёсны “Би”-гээс “ялгагддаг” ч түүнээс тусдаа бас нэг “Би” байх аргагүй. Энэ хоёрын харилцааг үгийн ердийн утгаар

хэлэх боломжгүй байдаг. Баттай таньсан трансценденталь туршлагын талбар нь (Selbsturfahrung) удирдамжийг өөрчлөх бүрд өөрийн сэтгэл судлалын зохих ёсны туршлагад шилжих ёстой. Ийм шилжилтээр Би-гийн адилсал гарцаагүй тогтоогддог; энэ шилжилт дээр үйлдсэн трансценденталь тунгаах эргэцүүлэгээр сэтгэл судлалын обьективчлол нь трансценденталь Би-гийн өөрийн-обьективчлол болж илэрнэ. Энэ нь жам ёсны удирдамжийн агшин бүрд апперцепци шаардагдах мэт байдаг. Хамгийн чухал нь бид: сэтгэл судлалын туршлага ба трансценденталь туршлага хоёрын талбарыг тэдгээрийн утгын “адилсал” нь зэргэлдээ болгодог, харин ялгаатай болгодог нь тэдгээрийн удирдамжийн солигдол гэдгийг санаж байх ёстой. Эпохег чанд сахин хэрэгжүүлэх үед сэтгэл судлалын субъектив төлөв нь трансценденталь субъектив төлөвт, харин сэтгэл судлалын интерсубъектив төлөв нь трансценденталь интерсубъективт урвана. Трансценденталь төлөв бол ухамсараар трансценденцичлэгдэж буй бүх бодит байдал (ертөнц)-ын оршин ахуй утга учрын уг сурвалж мөн. Учир нь бүхий л обьектив оршихуй “харьцангуй чанарт” болой. Юмсын оршихуйн тухай ухамсрын итгэл үнэмшил трансценденталь зүй тогтолд зохицсон интенцүүдийн нэгдэлд шүтсэн байдаг.

§ 4. Феноменологи нь универсаль ухаан болох нь

(Трансценденталь феноменологи.
Философи нь

үнэмлэхүй үндэслэлтэй универсаль
ухаан болох нь)

Трансценденталь феноменологи ба онтологи

Тийнхүү феноменологи хөгжих явцад бүх априори шинжлэх ухааныг универсаль онтологид жигдрүүлэх Лейбницийн санаа улам бодит болж феноменологи аргын догматик бус

шинэ үндэслэл дээр хэрэгжиж эхэлсэн. Феноменологи бол субъектив төлөв ба интерсубъектив төлөвт бүтсэн феномены тухай ухаан учраас ЕО IPSO аливаа оршихуйн боломжит хэлбэрийн априор ухаан мөн. Феноменологийн үйлчлэх хүрээ универсаль шинжтэй байдгийн учир нь интенциональ зохиомжоосоо хамаарахгүй априор байдаггүй, априор бүхний ухамсрын амьдралд аль нэг чиг шугамыг бүтээх чадвар нь түүнээс хамааралтай; тэгэхлээр зарим нэг априорийг тогтоох нь түүнийг тогтоосон субъектив үйл явцыг нээх ёстой.

Феноменологи ба оновчтой шинжлэх ухаануудын үндэслэгээний хямрал

Шинжлэх ухаанаас математик зэрэг априор салбарууд феноменологийн талбарт татагдан ормогц маргаан дагуулсан зарчмын “парадокст” тэд тушигдахгүй; харин феноменологиос шалтгаалахгүй априор болсон салбарууд феноменологид тулгуурлан байж л өөрийн үндэслэл хийгээд арга зүйн шүүмжлэлээс чөлөөлөгдөж чадна. Учир нь зарим нэг гарцаагүй үндэслэлд тулгуурлан позитив шинжлэх ухаан байх гэсэн тэдний эрмэлзэл нь феноменологи хэмээх универсаль эйдетик онтологийн салаа мөчир болохын хувьд хамааралтайг л харуулж байна.

Эмпирик шинжлэх ухааны феноменологи үндэслэгээ

Аливаа объектив чанарыг тэдгээрийн трансценденталь “сурвалжид” эргүүлэн хэрэгжүүлж буй а-приори бүтцийн универсумыг гаргах дундаршгүй ажил нь аливаа юмсын тухай универсаль шинжлэх ухааныг бүтээн босгох ажиллагааны нэг хэсэг гэж үзэж болно. Тийм универсаль ухааны салбар бүр, тэр дундаа позитив салбар нь ч априор үндэслэл дээр тогтох учиртай.

Феноменологи бүхэлдээ бүхний тухай философи болох нь

Тиймээс феноменологийг эцсийн ангилал нь дараах байдалтай байна. Үүнд эйдетик феноменологи, эсвэл универсаль онтологи нь анхдагч философи болно; харин бодит байдлын универсумын тухай ухаан буюу трансценденталь субъектив төлөвийн тухай ухаан нь хоёрдогч философи болно.

Эцэстээ философи бол бүх мэдлэгийн цогцын багтаасан универсаль ухаан гэж үздэг эртний грек ойлгоц, Платон, Картези нарын сэтгэлгээ болсон философийг зохих ёсоор нь сэргээсэн билээ.

Феноменологид эцсийн бөгөөд дээд зэргийн асуудал хамаарах нь

Бүх рационал асуудал, юутай ч “философийн” гэж үзсээр ирсэн асуудал бүхний хэлбэр ба тайлалын уг сурвалж нь трансценденталь туршлага юм уу эйдетик интуици болж хувирснаар тэд байр сууриа феноменологийн дотор бүрэн эзэлнэ. Философийн асуудалд холбогдолтой хүний “амьдралын” трансценденталь үйл ажиллагааг [универсаль учир холбогдлынхоо хувьд] феноменологи өөрөө танин мэднэ. Мөн амьдралын анхдагч хэлбэрүүдийг танин мэдэж, амьдралын анхны телеологи бүтцүүдийг шинжилж болно. Феноменологи бол универсаль оюун ухааны нэрийн өмнөөс ерөөс хүмүүн гэгч суралцаж буйгаас өөрцгүй. Амьдралын үндсүүдийг нээснээр, феноменологи нь ерөөс хүн төрөлхтний, бодитой бөгөөд үнэн хүн төрөлхтний тухай цаглашгүй санааг зорих шинэ ухамсрын урсгалыг чөлөөлөн гаргамай.

Метафизикийн асуудал, телеологийн, ёс зүйн, философийн түүхийн асуудал, шалгах дүгнэх асуудал гэх мэт бүхий л ач холбогдолтой асуудал, тэдгээрийн трансценденталь холбоос нь феноменологийн чадавхын хүрээнд оршино.

Феноменологийн товч замнал

Феноменологийн философи нь эртний грекийн философийн гол чигийг, Декартын философийн гол санааг хөгжүүлсэн төдий юм. Тухайн сэдвүүд нэг мөсөн алга болоогүй юм. Тэдгээр нь эмпиризм рационализм хоёрын талд хуваагдаж, Кантын философи, германы идеализмаар дамжин учир битүүлэг бидний цаг үед хүрч ирсэн билээ. Тэдгээрийг арга зүйн талаас сайжруулан боловсруулж дахин сэргээх учиртай байлаа. Тэдгээр нь эцсийн хязгаар үгүй шинжлэх ухаанд урам зориг өгч чадна.

Феноменологчид философийн систем бүтээх хандлагаас салж, мөнхийн философийн төлөөх нийтлэг ажил хэрэгт оролцохыг феноменологи шаардана.